



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

**Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой  
нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай**

Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 76.1.18 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн а/1021 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал нь компанийн дүрмийн 8.7.1-д заасан мэргэжлийн шаардлага хангаагүй байх тул Батболдын Батхуягийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тасалбар болгон цуцалсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.  
Үүнд:

|         |              |  |
|---------|--------------|--|
| Дарга:  | Д.Чимидлхам  | - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн            |
| Гишүүн: | Н.Ган-Эрдэнэ | - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн            |
|         | Д.Цолмон     | - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн |

3. Холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх захирал Б.Батхуяг, үүрэг гүйцэтгэгчээр томилогдож буй Л.Нарангэрэлийн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүлээлцүүлэхийг ажлын хэсэг /Д.Чимидлхам/-д үүрэг болгосугай.

4. Б.Батхуягийн ээлжийн амралтын олговор болон холбогдох бусад тооцоог зохих журмын дагуу хийж дуусгахыг ерөнхий нягтлан бодогч /Ж.Даш/-д даалгасугай.



ДАРГА

П.ДАВААДОРЖ



## ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

### Компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 76.1.18 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн а/1021 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын сул орон тоог нөхөх хүртэлх хугацаанд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Ерөнхий инженер Л.Нарангэрэлийг албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ерөнхий инженер Л.Нарангэрэлийг албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсний цалин, урамшуулалыг холбогдох хууль, журмын дагуу түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хувиар бодож олгохыг ерөнхий нягтлан бодогч /Ж.Даш/-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох хууль тогтоомж болон компанийн дүрмийг чанд сахиж, дотоод зохион байгуулалтыг сайтар хангаж ажиллахыг гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ДАВААДОРЖ